ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/212/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn<br>Ахлах аудитор : Б.Дагвасүрэн<br>Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn<br>Аудитор П.Ганцолмон<br>Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. **Аудитын санал дүгнэлт** ..... 2
2. **Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**
    2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
    2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан ..... 5
    2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 7
    2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 8
    2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
3. **Аудитын тайлан**
    3.1 Ерөнхий зүйл ..... 12
    3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 12
    3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12
    3.4 Материаллаг байдал ..... 13
    3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 13
    3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 14
    3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 14
    3.8 Аудитын гол асуудал ..... 14
    3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж ..... 14
    3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
    3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 15
4. **Аудитын илрүүлэлт** ..... 15


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24 № 1202/242
танай ______ -ны № ______ -т

ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Д.АНХТЭС-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

01?025365

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
## 2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **42,814,209.09** | **20,828,928.55** |
| **33** | **АВЛАГА** | 265,751.84 | - |
| **335** | **Бусад авлага** | 265,751.84 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 265,751.84 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 42,548,457.25 | 20,828,928.55 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,650,480.00 | 848,580.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,650,480.00 | 848,580.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 40,897,977.25 | 19,980,348.55 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 11,746,768.70 | 6,124,890.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,421,608.55 | 1,867,058.55 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 26,729,600.00 | 11,988,400.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **606,337,355.59** | **567,517,680.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 606,337,355.59 | 567,517,680.79 |
| **392** | **Биет хөрөнгө** | 596,734,689.10 | 558,017,680.79 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 377,273,641.66 | 377,273,641.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (16,640,558.54) | (24,055,431.98) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 233,191,750.00 | 210,191,750.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (114,359,805.55) | (112,643,138.87) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 353,861,224.65 | 351,723,163.55 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (267,206,156.90) | (268,296,305.13) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 77,267,413.80 | 68,935,516.47 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (46,652,820.02) | (45,111,514.91) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 9,602,666.49 | 9,500,000.00 |
| 39301 | Програм хангамж | 4,464,752.02 | 4,464,752.02 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (4,362,085.53) | (4,464,752.02) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,500,000.00 | 9,500,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **649,151,564.68** | **588,346,609.34** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **649,151,564.68** | **588,346,609.34** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 649,151,564.68 | 588,346,609.34 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 143,570,209.56 | 143,570,209.56 |
| 51101 | Өмч: - төрийн | 143,570,209.56 | 143,570,209.56 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 494,610,011.85 | 444,560,102.78 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 494,610,011.85 | 505,365,058.12 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (60,804,955.34) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 10,971,343.27 | 216,297.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **649,151,564.68** | **588,346,609.34** |

## 2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,221,687,109.70** | **813,223,403.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **524,883,748.00** | **144,185,603.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 524,883,748.00 | 144,185,603.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 498,454,704.00 | 144,185,603.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 329,732,692.00 | 119,718,556.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 21,427,179.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 168,722,012.00 | 3,039,868.00 |
| 120009 | Бусад орлого | 26,429,044.00 | - |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **51,427,261.70** | **31,048,400.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 645,376,100.00 | 637,989,400.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,000,000.00 | 600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 600,000.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 30,305,000.00 | 29,372,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт | 30,305,000.00 | 29,372,900.00 |
| 1330 | **Төсвийн захирагчдаас** | 12,236,106.70 | 1,075,500.00 |
| 133003 | Хөрөнгийн | 12,236,106.70 | 1,075,500.00 |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 7,886,155.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 7,886,155.00 | - |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,112,479,362.36** | **874,028,358.34** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,112,479,362.36** | **874,028,358.34** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 933,519,428.90 | 735,788,850.34 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 452,992,120.16 | 453,588,151.84 |
| 210101 | Үндсэн цалин | 342,344,647.16 | 341,479,451.84 |
| 210102 | Нэмэгдэл | 85,055,214.00 | 85,853,400.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,208,147.00 | 12,985,200.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,384,112.00 | 13,270,100.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 60,580,945.54 | 61,184,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,428,931.19 | 43,056,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,540,676.65 | 4,532,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,626,454.75 | 3,625,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 907,716.94 | 906,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,077,166.01 | 9,064,400.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,486,753.00 | 29,120,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,523,343.00 | 2,189,264.55 |
| 210302 | Түлш, халаалт | 24,170,400.00 | 23,364,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,793,010.00 | 3,566,235.45 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 31,042,073.08 | 41,409,828.70 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,487,783.08 | 29,278,328.70 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,717,800.00 | 10,276,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 490,390.00 | 555,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,346,100.00 | 1,299,100.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 267,300.00 | 267,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 267,300.00 | 267,300.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 252,700.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 252,700.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 5,370,900.00 | 11,371,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,370,900.00 | 11,371,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 25,134,794.00 | 12,289,066.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 247,500.00 | 247,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 164,350.00 | 313,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95,900.00 | 148,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 22,400.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 24,627,044.00 | 11,557,366.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 329,644,543.12 | 126,305,703.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 267,632,903.00 | 59,174,491.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 62,011,640.12 | 67,131,212.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 178,959,933.46 | 138,239,508.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 57,980,755.00 | 45,913,728.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 7,888,155.00 | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,379,000.00 | 5,990,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 45,713,600.00 | 39,923,728.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 24,352,442.46 | 12,195,572.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,352,442.46 | 12,195,572.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 14,159,847.00 | 9,779,050.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,159,847.00 | 9,779,050.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 82,466,889.00 | 70,351,158.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 82,466,889.00 | 52,674,704.00 |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | - | 17,676,454.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **109,207,747.34** | **(60,804,955.34)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **109,207,747.34** | **(60,804,955.34)** |

## 2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,570,209.56** | **10,971,343.27** | **386,163,044.47** | **540,704,597.30** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **143,570,209.56** | **10,971,343.27** | **386,163,044.47** | **540,704,597.30** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 109,207,747.34 | **109,207,747.34** |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,570,209.56** | **10,971,343.27** | **494,610,011.85** | **649,151,564.68** |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,570,209.56** | **10,971,343.27** | **494,610,011.85** | **649,151,564.68** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 10,755,046.27 | **10,755,046.27** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **143,570,209.56** | **10,971,343.27** | **505,365,058.12** | **659,906,610.95** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, | - | (10,755,046.27) | - | **(10,755,046.27)** |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (60,804,955.34) | **(60,804,955.34)** |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,570,209.56** | **216,297.00** | **444,560,102.78** | **588,346,609.34** |

## 2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,006,413,792.00** | **809,108,035.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **329,732,692.00** | **141,145,735.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 329,732,692.00 | 141,145,735.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 329,732,692.00 | 141,145,735.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 329,732,692.00 | 119,718,556.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 21,427,179.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **676,681,100.00** | **667,962,300.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 645,376,100.00 | 637,989,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,000,000.00 | 600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 600,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 30,305,000.00 | 29,372,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт | 30,305,000.00 | 29,372,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **859,964,392.00** | **783,836,365.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **859,964,392.00** | **783,836,365.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **688,892,613.54** | **645,596,857.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 453,257,872.00 | 453,322,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 342,610,399.00 | 341,213,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 85,055,214.00 | 85,853,400.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,208,147.00 | 12,985,200.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,384,112.00 | 13,270,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 60,580,945.54 | 61,184,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,428,931.19 | 43,056,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,540,676.65 | 4,532,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,626,454.75 | 3,625,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 907,716.94 | 906,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,077,166.01 | 9,064,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,486,753.00 | 29,120,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,523,343.00 | 2,189,264.55 |
| 210302 | Түлш, халаалт | 24,170,400.00 | 23,364,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,793,010.00 | 3,566,235.45 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,037,590.00 | 18,661,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,483,300.00 | 6,483,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,717,800.00 | 10,276,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 490,390.00 | 555,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,346,100.00 | 1,346,100.00 |
| **2105** | **Норматив зардал** | 267,300.00 | 267,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 267,300.00 | 267,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 252,700.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 252,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,370,900.00 | 11,371,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,370,900.00 | 11,371,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 507,750.00 | 12,289,066.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 247,500.00 | 247,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 164,350.00 | 313,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95,900.00 | 148,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 22,400.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 11,557,366.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 119,383,503.00 | 59,127,491.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 119,383,503.00 | 59,127,491.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **171,071,778.46** | **138,239,508.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 50,092,600.00 | 45,913,728.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,379,000.00 | 5,990,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 45,713,600.00 | 39,923,728.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 24,352,442.46 | 12,195,572.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,352,442.46 | 12,195,572.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 14,159,847.00 | 9,779,050.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,159,847.00 | 9,779,050.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 82,466,889.00 | 70,351,158.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 31,710,307.00 | 52,674,704.00 |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | 50,756,582.00 | 17,676,454.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **146,449,400.00** | **25,271,670.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **146,449,400.00** | **25,271,670.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **146,449,400.00** | **25,271,670.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 146,449,400.00 | 25,271,670.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 146,449,400.00 | 25,271,670.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(146,449,400.00)** | **(25,271,670.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **678,700,200.00** | **527,754,200.00** | **150,946,000.00** | **78%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **678,700,200.00** | **527,754,200.00** | **150,946,000.00** | **78%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **622,204,400.00** | **525,514,200.00** | **96,690,200.00** | **84%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **453,322,400.00** | **399,688,206.00** | **53,634,194.00** | **88%** |
| 210101 | Үндсэн цалин | 340,393,700.00 | 302,207,200.00 | 38,186,500.00 | 89% |
| 210102 | Нэмэгдэл | 86,253,400.00 | 70,351,814.00 | 15,901,586.00 | 82% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,985,200.00 | 14,291,386.00 | (1,306,186.00) | 110% |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 13,690,100.00 | 12,837,806.00 | 852,294.00 | 94% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **61,198,400.00** | **49,778,700.00** | **11,419,700.00** | **81%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,065,600.00 | 33,849,500.00 | 9,216,100.00 | 79% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,533,200.00 | 3,982,300.00 | 550,900.00 | 88% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,626,600.00 | 3,185,800.00 | 440,800.00 | 88% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 906,600.00 | 796,500.00 | 110,100.00 | 88% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,066,400.00 | 7,964,600.00 | 1,101,800.00 | 88% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **29,120,200.00** | **27,756,400.00** | **1,363,800.00** | **95%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,955,500.00 | 2,890,755.00 | 1,064,745.00 | 73% |
| 210302 | Түлш, халаалт | 23,364,700.00 | 23,552,905.00 | (188,205.00) | 101% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,312,740.00 | 487,260.00 | 73% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **18,661,800.00** | **8,860,800.00** | **9,801,000.00** | **47%** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,483,300.00 | 1,214,857.00 | 5,268,443.00 | 19% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,276,900.00 | 5,787,640.00 | 4,489,260.00 | 56% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 555,500.00 | 917,838.00 | (362,338.00) | 165% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,346,100.00 | 940,465.00 | 405,635.00 | 70% |
| **2105** | **Нормативт зардал** | **267,300.00** | **267,300.00** | **-** | **100%** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 267,300.00 | 267,300.00 | - | 100% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **252,700.00** | **379,100.00** | **(126,400.00)** | **150%** |
| 210604 | Урсгал засвар | 252,700.00 | 379,100.00 | (126,400.00) | 150% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **22,708,900.00** | **3,708,900.00** | **19,000,000.00** | **16%** |
| 210702 | Дотоод албан томилолт | 22,708,900.00 | 3,708,900.00 | 19,000,000.00 | 16% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **731,700.00** | **592,700.00** | **139,000.00** | **81%** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 247,500.00 | 160,000.00 | 87,500.00 | 65% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 313,300.00 | 313,300.00 | - | 100% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,500.00 | 97,400.00 | 51,100.00 | 66% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,400.00 | 22,000.00 | 400.00 | 98% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **35,941,000.00** | **34,482,094.00** | **1,458,906.00** | **96%** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,941,000.00 | 34,482,094.00 | 1,458,906.00 | 96% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **56,495,800.00** | **2,240,000.00** | **54,255,800.00** | **4%** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **56,495,800.00** | **2,240,000.00** | **54,255,800.00** | **4%** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,390,000.00 | 2,240,000.00 | 2,150,000.00 | 51% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 52,105,800.00 | - | 52,105,800.00 | 0% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **678,700,200.00** | **527,754,200.00** | **150,946,000.00** | **78%** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **649,327,300.00** | **527,754,200.00** | **121,573,100.00** | **81%** |
| **131007** | **Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих** | **649,327,300.00** | **499,618,700.00** | **149,708,600.00** | **77%** |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | - | 28,135,500.00 | (28,135,500.00) | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **29,372,900.00** | **-** | **29,372,900.00** | **0%** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 29,372,900.00 | - | 29,372,900.00 | 0% |

## 2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **115,579,197.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **115,579,197.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 115,579,197.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 16,200,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,200,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,752,500.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 7,752,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 91,626,697.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 83,453,401.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,173,296.00 |

## 3. **Аудитын тайлан**

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага Завхан Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар-т холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 213 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Завхан Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хот байгуулалтын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах; газрын харилцааны хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах; геодези, зураг зүйн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Завхан Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Дотоод аудитын нэгж байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг дахин тогтоож АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 813,223.4 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 813,223.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,100.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70 хувиар буюу 5,670.0 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 265.7 | - | -265.7 |
| Бараа | 42,548.5 | 20,829.0 | -21,719.5 |
| Үндсэн хөрөнгө | 606,337.3 | 567,517.6 | -38,819.7 |
| **Нийт хөрөнгө** | **649,151.5** | **588,346.6** | **-60,804.9** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 649,151.5 | 588,346.6 | -60,804.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө** | **649,151.5** | **588,346.6** | **-60,804.9** |

Авлага данс нь 264.7 мянган төгрөгөөр буурсан нь ажилтан албан хаагчдын авлагыг барагдуулсантай холбоотой.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 21,719.5 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал, бичиг хэргийн материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл буурсан холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 15,953.7 мянган төгрөгийн бараа материал бэлтгэсэн, тайлант хугацааны зарцуулалт 38,748,7 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 38,819.7 мянган төгрөгөөр буурсан нь тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг данснаас хөрөнгийн хасалт хийгдсэнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 25,271.6 мянган төгрөг, хандивын хөрөнгөөр 3,039.8 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус олж бэлтгэсэн, тээврийн

хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга нд хогшил данснаас 61,781.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 60,804.9 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 678,700.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 499,618.7 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 28,135.5 мянган төгрөгийн нийт 527,754.2 мянган төгрөгийн орлоготой, урсгал үйл ажиллагаанд 517,976.15 мянган төгрөгийг зарцуулсан байна. Орон нутгийн төсөвт 9,779.05 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 115,579.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, гэрээт ажлын хөлс 16,200.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээ, хураамжийн зардалд 7,752.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 91,626.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 145 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 3 байна.

Хугацаа хоцроосон мэдээлэл нь батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1, Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлан 2 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж, 1 акт хүргүүлснийг биелүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны мэдээлэлийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулж байх, Дотоод хяналтыг сайжруулах.

## 4. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 108,936.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, хөрөнгө орлогот аваагүй, НД-ийн авлага тусгаагүй гэх 4,541.5 мянган төгрөгийн алдааг залруулж, ибаримтгүй 88, 671.9 мянган төгрөг, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 15,723.0 мянган төгрөгийн алдаа илэрсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд тусгагдсан хөрөнгийн орлого 3,039.8 мянган төгрөгийн Тушаал шийдвэр, 1,501.7 мянган төгрөгийн авлагат тусгаагүй НДШ, 15,723.0 мянган төгрөгийн анхан шатны баримтуудын тамга тэмдэг гарын үсгийг бүрдүүлсэн тул залруулга хийгдсэн.

### 4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 4.3 Албан шаардлага өгөгдөөгүй.

### 4.4 Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Анхан шатны баримттай холбоотой асуудал***

- ✓ <u>Илрүүлэлт:</u> 15,723.0 мянган төгрөгийн анхан шатны баримт нь " үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтны гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно". гэсэн нягтлан бодохын бүртгэлийн заавар журмыг дагаж мөрдөөгүй .

- ✓ Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.
- ✓ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах;

**2.Татварын данстай холбоотой асуудал**

- ✓ 1.1 Илрүүлэлт: Тус байгууллага нь тайлант хугацаанд 139,594.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн боловч татварын сайт дахь ибаримтын бүртгэлээр 50,922.9 мянган төгрөг тайлагнагдаж 88,671.9 мянган төгрөгийн гүйлгээг илүү бүртгэж тайланд тусгасан байна.
- ✓ Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ГХБХБГазар | 5 | 108.9 | 3 | 4.5 | - | - | - | - | 2 | 104.4 |